



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/159/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Ц.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2021.02.05 № 2/15

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.


Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох



005020865

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,035,610.45</u>	<u>31,513,047.75</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	27,035,610.45	31,513,047.75
351	Түүхий эд материал	14,007,330.45	14,187,117.75
35110	Тусгай зориулалттай материал	14,007,330.45	14,187,117.75
35300	Бэлэн бүтээгдэхүүн	706,980.00	731,980.00
354	Хангамжийн материал	12,321,300.00	16,593,950.00
35410	Бичиг хэргийн материал	99,300.00	159,750.00
35420	Аж ахуйн материал	6,687,900.00	10,900,100.00
35470	Бусад хангамжийн материал	5,534,100.00	5,534,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>958,205,558.47</u>	<u>938,338,472.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	958,205,558.47	938,338,472.84
392	Биет хөрөнгө	943,905,558.47	924,038,472.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	919,078,168.00	919,078,168.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,630,086.16	-31,260,172.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,000,000.00	28,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,000,000.00	-28,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183,185,901.17	189,114,747.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	176,687,570.90	181,777,316.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,702,800.00	79,702,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,301,547.04	-52,377,646.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,557,893.40	1,557,893.40
393	Биет бус хөрөнгө	14,300,000.00	14,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,900,000.00	14,900,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>985,241,168.92</u>	<u>969,851,520.59</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>985,241,168.92</u>	<u>969,851,520.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	985,241,168.92	969,851,520.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,300,000.00	14,300,000.00
51101	Өмч: - төрийн	14,300,000.00	14,300,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	679,990,803.00	664,601,154.67
51210	Өмнөх үеийн үр дүн	679,990,803.00	679,990,803.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-15,389,648.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	290,950,365.92	290,950,365.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>985,241,168.92</u>	<u>969,851,520.59</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	555,241,844.81	776,972,359.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,441,944.81	24,185,059.41
120	Нийтлэг татварын бус орлого	14,441,944.81	24,185,059.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,441,944.81	24,185,059.41
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,441,944.81	24,185,059.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	540,799,900.00	752,787,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	534,776,900.00	581,872,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	534,776,900.00	581,872,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,023,000.00	170,914,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,023,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	170,914,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	583,079,418.68	792,362,007.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	583,079,418.68	792,362,007.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,017,719.68	790,146,551.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,362,726.00	453,660,729.00
210101	Үндсэн цалин	318,999,526.00	385,027,668.00
210102	Нэмэгдэл	69,243,200.00	59,750,561.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,120,000.00	8,882,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,666,028.00	55,959,921.00
210201	Тэтгэврийн даатгал	35,019,083.00	39,589,040.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,119,892.00	4,657,534.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,293,353.00	3,658,826.10
210204	Ажилгүйдлийн даатгал	748,516.00	799,066.17
210205	Эрүүл мэндийн даатгал	7,485,184.00	7,255,453.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,794,878.00	51,624,095.00
210301	Гэрэл, цахилгаан	3,115,366.00	2,747,699.00
210302	Түлш, халаалт	40,603,150.00	46,871,300.00
210303	Цэвэр, бохир ус	2,076,362.00	2,005,096.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,344,378.00	20,360,189.00
210401	Бичиг хэрэг	8,351,429.00	13,054,190.00
210402	Тээвэр, шатахуун	2,304,335.00	1,867,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,906,892.00	3,296,299.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,047,522.00	1,842,000.00
210408	Бараа материал акталсны зардал	4,434,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,732,500.00	1,668,938.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,080,000.00	333,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	1,247,838.90
210604	Урсгал засвар	1,252,500.00	88,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,342,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	3,342,000.00	72,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,730,864.13	15,248,217.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,273,700.00	517,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	6,000.00	6,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,861,864.13	13,974,717.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,044,345.55	191,552,461.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,234,600.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,809,745.55	24,330,761.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,061,699.00	2,215,456.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,040,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,040,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,699.00	1,815,456.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,699.00	1,815,456.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,837,573.87	-15,389,648.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,256,483.22	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,256,483.22	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-20,256,483.22	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-48,094,057.09	-15,389,648.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	749,887,344.25	971,628,376.39
11	ТАТВАРЫН ОРЛОГО	23,395,772.34	28,847,258.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	23,395,772.34	28,847,258.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,395,772.34	28,847,258.50
118001	Улсын тэмдэгтийн хураамж	23,395,772.34	28,847,258.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,691,671.91	189,993,817.89
120	Нийтлэг татварын бус орлого	185,691,671.91	189,993,817.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	185,691,671.91	189,993,817.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,691,671.91	189,993,817.89
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	540,799,900.00	752,787,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	534,776,900.00	581,872,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	534,776,900.00	581,872,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,023,000.00	170,914,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,023,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	170,914,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	749,887,344.25	971,628,376.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	749,887,344.25	971,628,376.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,738,201.00	750,571,844.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,050,695.00	444,579,450.00
210101	Үндсэн цалин	315,687,495.00	373,835,250.00
210102	Нэмэгдэл	69,243,200.00	61,240,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,120,000.00	9,504,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,978,059.00	65,041,200.00
210201	Тэтгэврийн даатгал	33,715,200.00	47,521,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,966,500.00	4,379,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,173,200.00	3,503,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	793,300.00	876,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,329,859.00	8,759,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,794,878.00	51,624,095.00
210301	Гэрэл, цахилгаан	3,115,366.00	2,747,699.00
210302	Түлш, халаалт	40,603,150.00	46,871,300.00
210303	Цэвэр, бохир ус	2,076,362.00	2,005,096.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,639,669.00	15,690,199.00
210401	Бичиг хэрэг	8,080,920.00	8,362,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,304,335.00	1,867,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,906,892.00	3,296,299.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	297,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,047,522.00	1,867,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,280,000.00	1,415,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,080,000.00	761,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	566,400.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	88,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,342,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	3,342,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,418,300.00	1,273,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,823,000.00	517,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	280,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	6,000.00	6,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,234,600.00	170,875,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		170875600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,234,600.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,149,143.25	221,056,532.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,040,000.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,040,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	185,713,370.91	191,809,273.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,699.00	1,815,456.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,395,772.34	28,847,258.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,395,772.34	28,847,258.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	728,084,860.09	00.00	1,033,335,226.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	728,084,860.09	00.00	1,033,335,226.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-48,094,057.09	00.00	-48,094,057.09
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	679,990,803.00	00.00	985,241,168.92
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	679,990,803.00	00.00	985,241,168.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	679,990,803.00	00.00	985,241,168.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,389,648.33	00.00	-15,389,648.33
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,300,000.00	290,950,365.92	664,601,154.67	00.00	969,851,520.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,446,500.00	579,696,244.00	1,750,256.00	99.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,152,700.00	444,579,450.00	573,250.00	99.87
210101	Үндсэн цалин	374,408,500.00	373,835,250.00	573,250.00	99.85
210102	Нэмэгдэл	61,240,200.00	61,240,200.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,504,000.00	9,504,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,041,200.00	65,041,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	47,521,900.00	47,521,900.00	-	100.00

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
210202	Тэтгэмжийн даатгал	4,379,800.00	4,379,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,503,900.00	3,503,900.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	876,000.00	876,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,759,600.00	8,759,600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,631,100.00	51,624,095.00	1,007,005.00	98.09
210301	Гэрэл, цахилгаан	3,120,000.00	2,747,699.00	372,301.00	88.07
210302	Түлш, халаалт	46,883,000.00	46,871,300.00	11,700.00	99.98
210303	Цэвэр, бохир ус	2,628,100.00	2,005,096.00	623,004.00	76.29
2104	Хангамж, бараа материалын зардал	15,701,500.00	15,690,199.00	11,301.00	99.93
210401	Бичиг хэрэг	8,362,500.00	8,362,200.00	300.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,867,900.00	1,867,700.00	200.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,296,300.00	3,296,299.00	1.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,900.00	297,000.00	9,900.00	96.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,867,900.00	1,867,000.00	900.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,455,300.00	1,415,800.00	39,500.00	97.29
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,500.00	761,400.00	39,100.00	95.12
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	566,800.00	566,400.00	400.00	99.93
210604	Урсгал засвар	88,000.00	88,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	72,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	72,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281,100.00	1,273,500.00	7,600.00	99.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	524,400.00	517,000.00	7,400.00	98.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	280,200.00	280,000.00	200.00	99.93
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	6,000.00	6,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,600.00	-	111,600.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,600.00	-	111,600.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	426,400.00	400,000.00	26,400.00	93.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	426,400.00	400,000.00	26,400.00	93.81
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	426,400.00	400,000.00	26,400.00	93.81
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
131001	Улсын төсвөөс санхүүжих	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	40.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40.00	40.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	33.00	33.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,023,000.00	170,914,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,023,000.00	170,914,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,023,000.00	170,875,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,023,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,023,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	170,875,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	170,875,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	38,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,023,000.00	170,875,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,023,000.00	170,875,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,023,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	170,875,600.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 03-наас 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1/1134 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 548794.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5487.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 792362.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7923.6 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 969851.5 мянган төгрөг болж өмнөх оноос 15389.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар тайлант оны үр дүнгээр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27035.6	31513	4477.4
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	27035.6	31513	4477.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	958205.5	938338.4	-19867.1
Үндсэн хөрөнгө	1226424.7	1232353.6	5928.9
Хуримтлагдсан элэгдэл	-268219.2	-294015.1	-25795.9
Нийт хөрөнгө	985241.1	969851.5	-15389.6
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	985241.1	969851.5	-15389.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	985241.1	969851.5	-15389.6

Авлага дансанд өмнөх оны үлдэгдэл байхгүй бөгөөд тайлант оны үйл ажиллагааг явуулахдаа тухайн онд үүссэн авлагыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31513,0 мянган төгрөг болж 4477,4 мянган төгрөгөөр өссөн нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас 19721.3 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1232353.6 мянган төгрөг болж 5928.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь УБЕГ-аас 5928.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2020.12.11-ний өдрийн А-1/2183 тоот тогтоолын дагуу шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь дээд газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5928.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн ба тайлант онд үндсэн хөрөнгө актлаагүй байна.

Биет бус хөрөнгө данс нь тайлант онд хөдлөл өөрчлөлт ороогүй бөгөөд Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14900.0 мянган төгрөг байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 776972.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 221730.7 мянган төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна.

Тайлант онд улсын төсвөөс 581872.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 189993.8 мянган төгрөг, орон нутгийн тэмдэгтийн хураамж 28847.2, нэмэлт санхүүжилтээр 170914.4 мянган төгрөгийн УИХ болон аймаг орон нутгийн ИТХ-ын сонгуультай холбоотой зардлын орлого орсныг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь тайлант онд УИХ, аймаг орон нутгийн ИТХ-н ээлжит сонгууль болсонтой холбоотой зардал, дээд газраас үнэ төлбөргүй авсан орлого байна. Үнэ төлбөргүй авсан орлого 24185.0 мянган төгрөг болж өмнөх оноос 9743.1 мянган төгрөгөөр өссөн нь шилжүүлж авсан хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсантай холбоотой байна. Мөн 170914.4 мянган төгрөгийн сонгуулийн зардал нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин гарсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 792362.0 мянган төгрөг болж өмнөх оноос 209282.5 мянган төгрөгөөр буюу 26 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ын зардал 44298.0 мянган төгрөг, сонгуультай холбоотой гарсан 170914,4 мянган төгрөгийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 612329.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 612329.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 32690.3 мянган төгрөгөөр хасагдаж 579639.0 мянган төгрөгөөр анхны батлагдсан төсөв ирсэн бол 2020 оны 06 дугаар сард өөрчлөлт орж 579639.0 мянган төгрөг болсон ба 2020.12.31-ны байдлаар 581872.9 мянган төгрөг болж төсвийн төслөөс 30456.4 мянган төгрөгөөр хасагдаж төсөв баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 581872.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 581872.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 581872.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 580096.2 мянган төгрөгийг зарцуулж 1776.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 580096.2 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 573.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 1007.0 мянга, хангамж бараа материалын зардлыг 11.3 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 39.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 11.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 26.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 70406 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 1776.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. ТГ-ийн бүлэгтэй тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 70406				
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
УРСГАЛ ЗАРДАЛ	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,872,900.00	580,096,244.00	1,776,656.00	99.69
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	445,152,700.00	444,579,450.00	573,250.00	99.87
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,041,200.00	65,041,200.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,631,100.00	51,624,095.00	1,007,005.00	98.09
Хангамж, бараа материалын зардал	15,701,500.00	15,690,199.00	11,301.00	99.93
Нормативт зардал	0.00	0.00	0.00	0.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,455,300.00	1,415,800.00	39,500.00	97.29
Томилолт, зочны зардал	72,000.00	72,000.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281,100.00	1,273,500.00	7,600.00	99.41
Бараа үйлчилгээний бусад зардал	111,600.00	0.00	111,600.00	0.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	0.00	0.00	0.00	0.00
ХӨТӨЛБӨР 70406				
АРГА ХЭМЖЭЭ 80802				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	426,400.00	400,000.00	26,400.00	93.81
Бусад урсгал шилжүүлэг	426,400.00	400,000.00	26,400.00	93.81
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	0.00	0.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	426,400.00	400,000.00	26,400.00	93.81

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд УИХ-ын болон аймаг орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын санхүүжилт 170914.4 мянган төгрөгийг тус газрын нэмэлт санхүүжилтийн 10030012420 тоот дансаар дамжуулан холбогдох зардалд нь зарцуулсан байна.

Хүснэгт 3. Улсын Их Хурлын сонгуулийн зардал

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	УБ-ын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, гэрээт ажилтны мөнгөн урамшуулал унаа хоолны зардал	62880.0	62880.0	0.0
2	Бичиг хэргийн материалын зардал	6827.8	6827.8	0.0
3	Томилолт унааны зардал	19677	19677	0.0
4	Сургалтын бусад зардал	4561.1	4561.1	0.0
7	Техник хэрэгсэл тээвэрлэх зардал	4120	4120	0.0
8	Шуурхай багийн зардал	390	390	0.0
	Нийт дүн	98455.9	98455.9	0.0

Хүснэгт 4. Аймаг орон нутгийн ИТХ-ын сонгуулийн зардал

мянган төгрөг

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Сонгуулийн бэлтгэл ажлын санхүүжилт	72486.3	
2	УБ-ын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, гэрээт ажилтны мөнгөн урамшуулал унаа хоолны зардал		50134.0
3	Бичиг хэргийн материалын зардал		2919.7
4	Томилолт унааны зардал		12747.6
5	Сургалтын бусад зардал		1218.00
6	Техник хэрэгсэл тээвэрлэх зардал		4120.0
7	Шуурхай багийн зардал		195
8	Үлдэгдэл төвлөрүүлэлт		1152.0
Нийт дүн		0.0	72486.3

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	5	36	36		
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	29	151	149	0	2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2020.04.20-ны өдрийн 1/461 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14542.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5460.9 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийж, 9081.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар бараа 5460.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийв. Үүнд:

1. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 1232353.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 31513.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө байгаа нь тооллогын бүртгэл нярвын тайлангаар баталгаажиж байна. Харин Эргэлтийн хөрөнгөд 5460.9 мянган төгрөгийн үнэ

Дансны нэр	Материалын нэр	Н.Б.Үнэ	Тоо	Дүн
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3 үйлдэлт принтер HP M126-495000	495000	1	495000
Машин тоног төхөөрөмж(компьютер)	Өнгөт принтер MF-913-889300	889300	1	889300
Машин тоног төхөөрөмж(компьютер)	Зөөврийн ком Dell empiration-14-2234300	2234300	1	2234300
Машин тоног төхөөрөмж(компьютер)	Принтер Canon3010-530300	530300	1	530300
	Дүн	4148900	4	4148900
Тавилга, аж ахуйн эд хогшил	Асар майхан-562000	562000	1	562000
Тавилга, аж ахуйн эд хогшил	Сургалтын ерөөний ширээ-270000	270000	2	540000
Тавилга, аж ахуйн эд хогшил	Халаагч тень-210000	210000	1	210000
	Дүн	1042000	4	1312000
	Нийт дүн	5190900	8	5460900

бүхий үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий хөрөнгийг бүртгэсэн байна. Хөрөнгийн жагсаалтыг хүснэгтээр харуулав. Энэ Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар

баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.29 дэх /Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ыг дагаж мөрдөнө/ заалт, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг тус тус байна.

Шийдвэрлэсэн нь: Эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгийн шинжтэй 8 нэр төрлийн 5460.9 мянган төгрөгийн хөрөнгийн бүртгэлийг аудитын явцад залруулга хийх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 9081.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас НДШ-ын зардалд 9081.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь тайлант онд НДШ-ын батлагдсан анхны төсөв нь НДШ-ын суутгалын хувь хэмжээний өөрчлөлтийг төсөвт тусган батлаагүй байсантай холбоотойгоор гүйлгэн зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2014.03.14-ны өдрийн 55 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2014.03.14-ны өдрийн 55 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн харцү тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

П.АМАРЖАРГАЛ
Огноо: 2021.02.05

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.05

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.05



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/159/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эргэлтийн хөрөнгөд 5460.9 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий хөрөнгийг бүртгэсэн байна.	5460.9	Залруулга хийх	Дарга Нягтлан бодогч	Ц.Мөнхжаргал Г.Бат-Очир
2	Цалингийн зардлаас НДШ-ын зардалд 9081.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.	9081.2	Зөвлөмж өгөх	Дарга	,
ДҮН		14542.1			